



ШИВЭЭ-ОВОО
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1/08

Смхүүг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлын төлөвлөгөө батлах тухай

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Шивээ Овоо" ХК-ийн "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2019 оны ажлын төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга/Х.Баяржаргал/, гүйцэтгэлийг хангаж ажиллахыг нийт хэлтэс, алба, хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж байхыг Хүний нөөцийн албаны хуулийн зөвлөх /Э.Мандахнаран/-д даалгасугай.

1 дүгээр хавсралт: 5 хуудастай

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ц.ЭНХТҮВШИН



“Шивээ-Овоо” ХК-ний Гүйцэтгэх захирлын
2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн
А/08 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2019 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ”

| № | Хийх ажил | Хугацаа | Хэрэгжүүлэх арга хэлбэр | Хариуцах нэгж, албан тушаалтан | Үр дүн |
|----|--|------------------------|--|---|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. |
| 1. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хууль, эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.1, 9.1.2 | 2019 оны 2, 4-р улирал | 1.1.Уурхайн ажилтнуудад шинэчлэгдэн гарсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрх зүйн актын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Хуулийн зөвлөх, Сургалтын менежер | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн болон бусад хууль, дүрэм, журам, эрх зүйн актын талаарх үндсэн ойлголт, мэдлэгийг нийт ажилтнуудад олгох болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болно. |
| | | Тухай бүр | 1.2.Шинээр ажилд орсон ажилтнуудад явуулах сургалтын хөтөлбөрт ГХУС хууль эрх зүйн асуудлыг тусгаж хэрэгжүүлэх, авлига, гэмт хэрэг зөрчил, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх заавартай танилцуулж байх; | Хүний нөөцийн алба, Сургалтын алба, Хуулийн зөвлөх | |
| | | 2019 ондоо | 1.3.Компанийн хэмжээнд камерын хяналтын систем суурилуулах, хяналтыг сайжруулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс | |
| | | 2019 ондоо | 1.4.Ажилтнууд болон алба, хэсгийн удирдлагын саналыг авч гэмт хэргийн хор хөнөөл, хариуцлага, ял шийтгэлийн талаарх мэдээллийг мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан хаагчдыг урьж мэдээлэл авах; | Сургалтын менежер | |

| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. |
|----|----|---|---|--|--|
| | | Улирал тутамд | 1.5.Шаардлагатай гэж үзвэл удаа дараа сахилгын шийтгэлд холбогдож байгаа ажилтнууд, удаа дараа архи уусан ажилтнуудад мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзуулж сэтгэл засах сургалт хийх; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Хүний нөөцийн алба | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох эрх зүйн болон сэтгэл зүйн дотоод ухамсрын мэдлэг, түүнээс хамааралгүй үүсэхгүй амьдрах боломжтойг ойлгуулах ангид байлгах үр дүнг бий болгох зорилготой. |
| | | 2019 оны нийтээр амрах баяр болон тэмдэглэлт өдрүүдэд | 1.6.Хөдөлгөөнт эргүүлийн ажлыг зохион байгуулах график төлөвлөгөө гаргаж, батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу ажиллахыг хэлтэс, алба, хэсгийн дарга нарт тараах; | Захирлын зөвлөлийн гишүүд, Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс | Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Архи согтуурахтай тэмцэх тухай хууль гэх мэт хуулиудыг мөрдүүлэх иргэд, ажилтнуудыг хамгаалах оновчтой үйл ажиллагаа болно. |
| | | Тухай бүр | 1.7.Хөдөлгөөнт эргүүлийн ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн хэлтэс, алба, хэсгүүд тухай бүр илтгэх хуудсаар холбогдох албан тушаалтанд мэдээлж байх; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Хүний нөөцийн алба | |
| | | Тухай бүр | 1.8.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг тухай бүр тушаалаар баталж ажиллуулах; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс | |
| | | 2019 оны 1, 3 дугаар улиралд | 2.1.Архидан согтуурахтай тэмцэх олон нийтийн үүсэл санаачилгыг дэмжих зорилгоор архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулдаг, бүлгэм, төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах, сургалт зохион байгуулах; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Дугуйлангийн гишүүд | Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар ажилтнуудад мэдлэг, мэдээлэл олгох, түүнээс ангид байлгах хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. |

| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. |
|----|--|-----------|---|---|---|
| 2. | Архидан согтуурахын эсрэг авах арга хэмжээний хүрээнд Хууль, Эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээл сурталчилгааны хөтөлбөр | Тухай бүр | 2.2.Компанийн нийт ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд, компанийн харьяаллын ахмад настан, МШӨ-тэй, групптэй уурхайчдад архины хор хөнөөлийн талаар байнга сурталчлан таниулах; | Сургалтын менежер, хэлтэс, алба, хэсгийн дарга нар | |
| | | Тухай бүр | 2.3.Архидан согтуурахын эсрэг болон нийгмийн дэг журмыг сайжруулахтай холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомжийг судалж, хэрэгжүүлэх; | Хуулийн зөвлөх | Хуулийн хэрэгжилтийг хангах, хамт олон, гэр бүлийн хандлагыг өөрчлөх замаар архидалттай тэмцэх, эрүүл аж төрөх ёс, амьдралын зөв хэвшлийг бүрдүүлэхийг бүх талаар дэмжих боломжийг бий болгоно. |
| | | Тухай бүр | 2.4.Баяр ёслолын арга хэмжээг архигүй тэмдэглэж хэвшихийг өөрөөсөө болон гэр бүлээсээ эхэлж, архинд бусдыг уруу татахгүй байлгаж хэвшүүлэх; | Компанийн нийт ажилтнууд | |
| 3. | Аймаг, сумын хууль, хяналтын байгууллага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах хүрээнд Хууль, эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг | Тухай бүр | 3.1.ГХУС тухай хууль, ЗГ-ын 2012.07.25-ны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Хөтөлбөр”-ийн хүрээнд дэх шаардлагатай мэдээ мэдээллийг хуулийн зөвлөх сар бүр авч байх; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Хуулийн зөвлөх | Хөтөлбөрийг хэрэгжих явцыг идэвхжүүлэх мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч үйл ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдолтой. |
| | | Тухай бүр | 3.2.Удаа дараа архидан согтуурч сахилгын шийтгэл хүлээсэн, архины хамааралтай ажилтнуудыг шаардлагатай гэж үзвэл Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх тухай хуульд зааснаар албадан эмчилгээнд явуулах талаар сум, багийн Засаг дарга, цагдаагийн хэсэгт санал оруулах; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Хуулийн зөвлөх | Хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан болон гарч болзошгүй эрсдэлийг бууруулах, |

| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. |
|----|---|-------------------------|---|---|--|
| | | Байнга | 3.3.Аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах; | Хүний нөөцийн алба, Хуулийн зөвлөх | Хамтын ажиллагаа сайжирна. |
| | | Тухай бүр | 3.4.Хууль, хяналтын байгууллагаас ирсэн бичиг, авах арга хэмжээний тухай ажлыг зохион байгуулж, хариуг тогтмол өгч байх; | Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтэс, Хуулийн зөвлөх | Хууль хяналтын байгууллагын мэдээлэл, эргэх холбоо, ажлын чанар сайжирна. |
| 4. | Сургалт, сурталчилгаа, олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд Хууль, эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр | Байнга | 4.1.Компанийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аливаа хийсэн ажлыг тухай бүр компанийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах; | Хэлтэс, алба, хэсгийн дарга нар, олон нийттэй харилцах ажилтан | Ажилтнууд болон иргэдийн шаардлагатай мэдээллээр хангах, мэдээлэл түгээх, ил тод байдлыг сайжруулна. |
| | | Байнга | 4.2.Спорт заалыг тогтмол ажиллуулж, хувиар гарган хэлтэс, хэсэг, албаны ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх; | Хүний нөөцийн алба, Хаялга спорт клуб | Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх. |
| | | 2019 оны 10 дугаар сард | 4.3.Сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулах; | Хүний нөөцийн алба, Хуулийн зөвлөх, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн | Компанийн нийгмийн хариуцлагыг өргөжүүлэх өсвөр үеийнхний эрх зүйн мэдлэг дээшлүүлэх болно. |
| 5. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвх санаачилгыг дэмжих, урамшуулах ажлын хүрээнд | Тухай бүр | 5.1.Тухай бүрд Компанийн төлөвлөгөөг харгалзан төсөв баталж хэрэгжүүлэх. | Хүний нөөцийн алба, Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн | Хуулийн хэрэгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх болно. |

| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. |
|----|----|------------|--|--|--|
| | | 2019 ондоо | 5.2.Хэлтэс, алба, хэсэг нэгжүүдийн дунд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хуулийн чиглэлээр тэмцээн зохион байгуулах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс | Ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх багаар ажиллах чадавхыг дээшлүүлэх болно. |

---oOo---